



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК

Танилцуулга
2019 оны 1 дүгээр сар

Улаанбаатар
2019



1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ


Мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 24.6 хувиар өсч 19.6 их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн 9.7 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 5.7 нэгж хувийг төгрөгийн харилцах, 4.8 нэгж хувийг валютын харилцах, 3.4 нэгж хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлсэн байна.

M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 24.6%-иар нэмэгдсэн байна.



Нийт хадгаламжийн хэмжээ 13.1 их наяд төгрөгт хүрснээс 84.4 хувь буюу 11.1 их наяд төгрөг нь иргэдийн, 15.6 хувь буюу 2 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Нийт хадгаламжийн 22.4 хувь нь гадаад валютын хадгаламж байна. Харин иргэдийн хадгаламжийн 18.7 хувийг, байгууллагын хадгаламжийн 42.8 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 18.7%-иар өсч 13.1 их наяд ₮-т хүрчээ.




Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 168.3 тэрбум төгрөгөөр өсчээ. Тодруулбал гадаад валютын харилцахын өсөлтийг санхүүгийн байгууллагын харилцах, төгрөгийн хадгаламжийн өсөлтийг иргэдийн хадгаламжийн өсөлт тайлбарлаж байна. Харин төгрөгийн харилцах буурсан нь хувийн байгууллага болон иргэдийн харилцах буурсантай холбоотой байна.

M2 өмнөх сараас 168.3 тэрбум ₮-өөр өсөв.



M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 19.2 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 892 тэрбум төгрөгтэй тус тус тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал M2 мөнгөний өсөлтийн 15.5 нэгж хувийг ГЦА-ын өсөлт, үлдсэн 9.1 нэгж хувийг ДЦА-ын өсөлт бүрдүүлжээ. ГЦА-ын өсөлт банкуудын гадаад цэвэр активын, харин ДЦА-ын өсөлт хадгаламжийн байгууллагын олгосон зээлийн өсөлттэй холбоотой байна.

M2 мөнгөний жилийн өсөлтийн дийлэнх хэсгийг ДЦА-ын өсөлт бүрдүүлж байна.



2. БАНКУУДЫН ЗЭЭЛ

Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 26.0 хувиар, үүнээс иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 35.5 хувиар өсч 9.0 их наяд төгрөгт, хувийн байгууллагынх 15.7 хувиар өсч 7.9 их наяд төгрөгт тус тус хүрчээ.


Нийт зээлийн үлдэгдэл 17.1 их наяд ₮ -т хүрч, жилийн 26.0%-иар өсөв.



Нийт зээлийн үлдэгдлийн 15.3 хувь буюу 2.6 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний валютын зээл байна. Тодруулбал иргэдийн зээлийн 1.6 хувь, хувийн байгууллагын 30.5 хувь нь гадаад валютаар олгосон зээл байна.

Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 1,378.1 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 804.5 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Шинээр олгосон зээлийн 19.2 хувь буюу 287.5 тэрбум төгрөгийг гадаад валютаар олгожээ.

Тайлант сард 1,497.2 тэрбум ₮-ийн зээл олгогдож, 1,517.2 тэрбум ₮ эргэн төлөгдлөө.



Өмнөх сартай харьцуулахад нийт зээлд эзлэх чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн зээлийн хувь тус тус өөрчлөгдөөгүй байна. Чанаргүй зээлийн 85.1 хувийг, хугацаа хэтэрсэн зээлийн 81.5 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.


Чанаргүй зээл нь нийт зээлийн 10.4%, хугацаа хэтэрсэн зээл 4.9% байна.



Чанаргүй зээлийн үлдэгдэл 1,782.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 3.6 тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээлийн 20.1 хувь нь гадаад валютаар олгогджээ.


Чанаргүй зээлийн 26.4 хувийг уул уурхай, 20.6 хувийг боловсруулах, 13.8 хувийг барилга, 8.4 хувийг үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл эзэлж байна.

Нийт чанаргүй зээлийн 85.1 хувь нь хувийн байгууллагын, 14.3 хувь нь иргэдийн зээл



Тайлант сард хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл өмнөх сараас 68.0 тэрбум төгрөгөөр буурчээ. Үүнд, барилгын салбарын зээл 66.3 тэрбум, худалдааны салбарын зээл 60.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан. Харин уул уурхайн салбарын зээл 10.8 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг худалдаа, барилга, боловсруулах, уул уурхайн салбарын зээл бүрдүүлэв.



Тайлант сард хувийн байгууллагад 698.8 тэрбум төгрөгийн зээл олгогдсоны 38.3 хувь буюу 267.7 тэрбум төгрөгийн зээл гадаад валютаар олгогджээ. Худалдаа, уул уурхай, боловсруулах, барилгын салбарт дийлэнх зээл олгогдсон байна.

Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц



Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 52.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс картын зээл 22.4 тэрбум төгрөг, худалдааны зээл 3.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Иргэдийн зээлийн 37 хувийг орон сууцны зээл (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар) бүрдүүлэв.




Тайлант сард иргэдэд 757.1 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 2.6 хувь буюу 19.8 тэрбум төгрөгийн зээл гадаад валютаар олгогджээ. Иргэдэд шинээр олгосон зээлийн дийлэнх буюу 23.6 хувийг цалин, тэтгэвэр, 23.2 хувийг хадгаламж барьцаалсан, 16.9 хувийг картын зээл тус тус бүрдүүлсэн байна.

Иргэдэд шинээр олгосон зээлийн бүтэц



ЖДҮ-ийн зээлийн дийлэнх хувийг худалдаа, боловсруулах, барилгын салбарын зээл эзэлж байна




ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 3,388.7 тэрбум төгрөгт хүрснээс 31.3 хувийг худалдааны салбарт, 15.9 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 11.5 хувийг барилгын салбарт, 8.7 хувийг үйлчилгээний салбарт тус тус олгосон байна. ЖДҮ-ийн зориулалтаар олгосон нийт зээлийн үлдэгдлийн 3.2 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 11.6 хувь нь чанаргүй зээлд ангилагдсан байна.

3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


2019 оны 1 дүгээр сарын байдлаар 93894 зээлдэгч нийт 4.4 их наяд төгрөгийн ипотекийн зээлтэй байна. Үүнээс хөтөлбөрийн эх үүсвэрээр 69461 зээлдэгч 3.3 их наяд төгрөгийн зээл авчээ.

Ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 4.2%-иар өсчээ.



Ипотекийн зээлийн үлдэгдлийн 74.8 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 23 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.2 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна.

Ипотекийн зээлийн 74.8 хувийг хөтөлбөрийн зээл эзэлж байна.



Орон нутгийн ипотекийн зээл¹-ийн 78 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 21.2 хувь нь банкны өөрийн эх үүсвэрээр, 0.8 хувь нь бусад эх үүсвэрээр олгогдсон ба нийт 24553 ипотекийн зээлдэгч байна.


Нийт ипотекийн зээлийн 936.6 тэрбум төгрөг буюу 21.2 хувь нь орон нутаг дахь банкны салбараас олгосон зээл байгаа бол худалдан авсан орон сууцны байршлаар нь авч үзвэл нийт зээлийн 17.2 хувь болох 759.2 тэрбум төгрөг орон нутагт ногдож байна.

¹ Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 17.2 хувийг орон нутагт байршилтай орон сууцанд олгожээ.



Ипотекийн зээлийн 82.8 хувь нь Улаанбаатар хотод байршилтай орон сууц худалдан авахад зарцуулагджээ.



Тайлант сард 37.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноос 36 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 64 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.8 хувь нь хэвийн, 1.9 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.4 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 56.3 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 42 хувийг хөтөлбөрийн зээл, 1.7 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.

Өмнөх сартай харьцуулахад хугацаа хэтэрсэн зээл 21.6 тэрбум төгрөг, чанаргүй зээл 2.9 тэрбум төгрөгөөр тус тус өсөв.



Тайлант сард шинээр 609 зээлдэгчдэд ипотекийн зээл шинээр олгожээ.



Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 12.5% болж өмнөх сараас 2.1 нэгж хувиар, өмнөх жилийн мөн үеэс 1 нэгж хувиар тус тус өсчээ.

Шинээр олгосон ипотекийн зээлийн дундаж хүү өмнөх сараас 2.1 нэгж хувиар өсчээ.



4. ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ ХАНШ

Тайлант сард төгрөгийн ам.доллартай харьцах ханш аажмаар суларсаар сарын эцсийн байдлаар 2628.70 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 0.6 хувиар чангарсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 2649.68 төгрөг байв.

Төгрөгийн ханш ам.долларын эсрэг чангарав.



Төгрөгийн юаньтай харьцах дундаж ханш өмнөх сараас 1.9 хувиар суларч 390.38 төгрөг байв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 385.97 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 395.17 төгрөг байлаа.


Төгрөгийн ханш юаны эсрэг сулрав.



5. ХҮҮ

2019 оны 1 дүгээр сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 10.6 хувь буюу өмнөх оны үеэс 1.8 нэгж хувиар буурсан байна. Гадаад валютын хүү өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар буурч 4.6 хувьд хүрсэн байна. Иргэдээс татсан төгрөгийн хадгаламж 11.4 хувь, хувийн байгууллагаас татсан хадгаламж 5.6 хувийн хүүтэй байна.

Шинээр татсан нийт хадгаламжийн хэмжээ, хүү




Шинээр татсан нийт ₮-ийн хадгаламжийн хүүний тархалт



Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 17.2 хувьтай бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.2 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт гадаад валютаар олгосон зээлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар буурч 9.6 хувьд хүрчээ. Иргэдэд шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү 18.0 хувь, гадаад валютын зээлийн хүү 6.3 хувьтай байна. Харин хувийн байгууллагад олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 16.5, валютын зээлийн ЖДХ 9.9 хувьтай байна.

Шинээр олгосон нийт зээлийн хэмжээ, хүү



Шинээр олгосон нийт ₮-ийн зээлийн хүүний тархалт




2019 оны 1 дүгээр сард нийт төгрөгийн хадгаламжийн ЖДХ 12.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурчээ. Харин нийт гадаад валютын хадгаламжийн ЖДХ 4.9 хувьтай байна. Тайлант сард иргэдийн хадгаламжийн үлдэгдлээрх ЖДХ 12.1 хувь, гадаад валютын хүү 4.8 хувьтай байгаа бол тухайн сарын хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн ЖДХ 11.4 хувь, гадаад валютын хүү 5.3 хувьтай байна.

Нийт хадгаламжийн үлдэгдэл, хүү




Мөн тайлант сард нийт төгрөгийн зээлийн үлдэгдлээрх ЖДХ 17.1 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 10.6 хувьтай байна. Үүнээс иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 18.0 хувьтай, гадаад валютын зээлийн ЖДХ 13.3 хувьтай байна. Хувийн байгууллагын зээлийн ЖДХ 15.5 хувьтай, гадаад валютын зээлийн хүү 10.5 хувьтай байна. Нийт төгрөгийн зээлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар, гадаад валютын зээлийн ЖДХ 0.6 нэгж хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.


Нийт зээлийн үлдэгдэл, хүү



Нийт ₮-ийн хадгаламжийн үлдэгдлийн хүүний тархалт



Нийт ₮-ийн зээлийн үлдэгдлийн хүүний тархалт



6. ИНФЛЯЦИ

Тайлант сард Улаанбаатар хотын жилийн инфляци 8.1 хувьд хүрч өмнөх сараас нэмэгдсэн байна. Үүнээс 5.1 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 3.0 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна. Хүнснээс бусад барааны үнэд хатуу түлш, автобензин, эм, тариа, хувцасны үнийн өсөлт, хүнсний барааны бүлгийн үнэд мах болон цагаан будааны үнийн өсөлт голлон нөлөөлжээ. Харин хүнсний ногооны үнэ буурсан байна.

УБ хотын хэмжээнд сарын инфляци 0.3 хувьд хүрсэн байна. Өмнөх сараас үнийн түвшин нэмэгдэхэд хүнсний бараа 0.7 нэгж хувийг, хүнснээс бусад бараа -0.4 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Хүнсний барааны үнэ өсөхөд мах болон цагаан будааны үнийн өсөлт нөлөөлсөн бол хүнснээс бусад бараа өсөхөд хатуу түлш, бэлэн хувцас, автобензиний үнийн өсөлт нөлөөлжээ.

УБ хотын жилийн инфляци 8.1 хувь



УБ хотын сарын инфляци 0.3 хувь



ХАВСРАЛТ

1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Зураг 1.1. М2 Мөнгөний сарын өсөлтийн бүтэц




Зураг 1.2. Нөөц мөнгөний бүтэц




2. ЗЭЭЛ


Зураг 2.1. Зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Зураг 2.2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /гол салбараар/




Зураг 2.3. Тайланд сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл




Зураг 2.4. Тайлант сард шинээр олгосон зээл (салбараар)




Зураг 2.5. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл




Зураг 2.6. Чанаргүй зээлийн дүн



Зураг 2.7. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл




Зураг 2.8. ЖДҮ-ийн зээл дэх чанаргүй зээлийн хувь, салбараар




Зураг 2.9 Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц



Зураг 2.10. Орон нутагт шинээр олгосон, төлөгдсөн зээл



Зураг 2.11. Орон нутгийн зээлийн үлдэгдэл /тэрбум/



Зураг 2.11. Орон нутгийн чанаргүй зээлийн эзлэх хувь



3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

Зураг 3.1. Ипотекийн зээлийн үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрээр




Зураг 3.2. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар тэрбум ₮



Зураг 3.3. Улаанбаатар хотын ипотекийн зээлийн үлдэгдэл, худалдан авсан орон сууцны байршлаар




Зураг 3.4. Орон нутгийн ипотекийн зээлийн үлдэгдэл



Зураг 3.5. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн ашиглалтанд орсон он



Зураг 3.6. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ



Зураг 3.7. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн орлогын тархалт



Зураг 3.8. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл

